



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/184

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх
тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 1 дүгээр баг, 15 дугаар байрны зүүн талд байршилтай, иргэн Шарын Цэндмаагийн автогаражийн зориулалттай 21 м2 газрыг “Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ”-ний дагуу иргэн Баяуд овогт Ганхуягийн Наранцэнгэлд “Автогараж”-ийн зориулалтаар, 21 м2 газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмшигч иргэн Ганхуягийн Наранцэнгэлд үүрэг болгосугай.

3. Газар эзэмшигч иргэн Ганхуягийн Наранцэнгэлтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны А/184 дугаар захирамжийн хавсралтын 9 дахь хүснэгтийн Ш.Цэндмаад холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

42121*-57